



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 11 сарын 09-ны
өдрийн 5534 дугаарт бүртгэв.

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 05 өдөр

дугаар 51/778

НОМГОН

Улсын тэмдэгтийн хураамжийн
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "д", 18 дугаар зүйлийн 18.2, 19 дүгээр зүйлийн 19.1.4, 25 дугаар зүйлийн 25.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус V хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Шийдвэрийг холбогдох байгууллага, ард иргэдэд сурталчилан таниулж хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.
4. Энэ тогтоолыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА

Э.ЭНХБАТ

012/047

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН
ХЭМЖЭЭГ ТОГТООСОН ЖАГСААЛТ

1. Аймаг, сумдын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.
 - 1.1. Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500,000.0 төгрөг;
 - 1.2. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100,000.0 төгрөг;
 - 1.3. Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 150,000.0 төгрөг;
 - 1.4. Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 50,000 төгрөг, гэрээг сунгахад 30,000 төгрөг;
 - 1.5. Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад 80,000.0 төгрөг;
 - 1.6. Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход 80,000.0 төгрөг;
 - 1.7. Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтэлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 60,000.0 төгрөг;
 - 1.8. Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 12,000.0 төгрөг;
 - 1.9. Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход 2,500.0 төгрөг;
 - 1.10. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад 800,000.0 төгрөг;
 - 1.11. Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой мал бол 3,000.0 төгрөг, 10-аас дээш тооны толгой мал бол 3,000.0 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд 100 төгрөг нэмж;
 - 1.12. Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 2,500.0 төгрөг;

1.13. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 1,500.0 төгрөг;

1.14. Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд 6,000.0 төгрөг;

1.15. Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход 0-10 килограмм бол 2,000.0 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 100 төгрөг нэмж;

1.16. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдэд олгоход 250,000.0 төгрөг, иргэнд 180,000.0 төгрөг;

1.17. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сумын Засаг дарга олгоход 100,000.0 төгрөг;

1.18. Мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2,500.0 төгрөг;

1.19. Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 280,000.0 төгрөг.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

2.1. Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 400,000.0 төгрөг, бусад сумд 250,000.0 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн сумд 200,000.0 төгрөг, бусад сумд 100,000.0 төгрөг;

2.2. Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 200,000.0 төгрөг, бусад сумд 100,000.0 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн сумд 50,000.0 төгрөг, бусад сумд 40,000.0 төгрөг;

2.3. Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 600,000.0 төгрөг, бусад сумд 350,000.0 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн сумд 300,000.0 төгрөг, бусад сумд 200,000.0 төгрөг;

2.4. Спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн сумд 300,000.0 төгрөг, бусад сумд 200,000.0 төгрөг, тусгай

зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн сумд 150,000.0 төгрөг, бусад сумд 100,000.0 төгрөг.

3.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасны дагуу энэ журмын 2.1-д заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн журмын 2.2 дахь заалт, энэ журмын 2.3-т заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн журмын 2.4 дэх заалт тус тус хамаарахгүй.

4.1.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50,000.0 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

5.Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

5.1.Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгох

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
6м ³ хүртэл	3000
6-10м ³ хүртэл	4500
10-20м ³ хүртэл	6000
20-60м ³ хүртэл	15000

5.2.Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
8м ³ хүртэл	4500
8-10м ³ хүртэл	6000
10-20м ³ хүртэл	10500
20-30м ³ хүртэл	15000

5.3.Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/
0-10м ³	3000
10-20м ³	3600
20-30м ³	4500

5.4.Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 2,000.0 төгрөг нэмж;

5.5.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнс, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хосронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 2,000.0 төгрөг, 10 куб метрээс дээш бол 2,000.0 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд 150 төгрөг нэмж;